

**МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ НЭГЭН ХЭЛЛЭГИЙН
АНГЛИ ОРЧУУЛГЫН ТУХАЙД**

Д.Отгонтуяа *

Монголын Нууц Товчоо (МНТ) зохиолын үг, хэлц, хэллэг, нэр томъёоны зарим орчуулга нэлээд зөрөөтэй бөгөөд үүнийг олон эрдэмтэн судлаачид хажуугийн хятад хадмалд тулгуурлан орчуулсантай холбон үздэг.

Энэхүү өгүүлэлд Монголын Нууц Товчооны 121-р зүйлийн *'ke'eli niketen keke qaqcatan'* [3122,3123: 37b-2-4, 50] гэсэн хэллэгийн талаар гадаад дотоодын эрдэмтдийн хөрвүүлж тайлбарласныг харьцуулан авч үзье.

Энэ хэллэгийн талаар эрдэмтэн Ш.Гаадамба “Энэ үгийг бид урьд бичсэн нэг өгүүлэлдээ (10, 156-161) «кэкэ» гэдэг нь «экэ ганцтан» гэсэн утгатай гэж тайлбарласан тул тэр ёсоор «кэкэ (экэ)» гэж сэргээсэн болно. Нууц товчооны үед хэдийгээр энэ үг «экэ» гэсэн дуудлагатай боловч «кэкэ» (эх) гэсэн энэ цэцэн үгийн II мөрийн «кэгэли» гэдэг үгтэй авиа ижилсэн шүлэг болсон тул түүнийг эвдэхгүй гэж «кэкэ» (экэ гэлгүй) чигээр үлдээжээ. Нөгөө талаар эхийн ус «кэкэ-ийн усу» гэж байгаад улмаар кэкэ усу кэкэ экэс эгш гэх мэтээр хувирсан нь ил байна. Эхийн ус буюу «икэс» гэдэг үгийг Булган аймгийн зарим буриад ястны аялгуунд одоо ч «хэхэ» гэж хэлдгийг Цэрмаа багш өгүүлэлдээ заасан байна. (89,81-82). Цэрмаа багшийн эхийн усыг одоо ч «кэкэ» гэж хэлдэг заншил байгаагаас «кэкэ» гэдэг «экэ» гэсэн үг биш гэж няцааж байгаа боловч үнэндээ хуучин монгол бичигт «икэс» (эхийн ус) гэдэг үг «кэкэ» буюу «экэ» гэдэг үгнээс үүссэн гэдгийг давхар баталж байна. Үүнээс үзвэл Нууц товчооны галигт «кэкэ» биш «кэкэ ус» гэсэн хоёр үг байгаад тэр «ус» гэдэг үг нь хаягдсаны учир хятад галигт «кэкэ» гэдгийг «экэс буюу эхийн ус» гэсэн хадмал хятад орчуулга хийгдсэн байх гэж санагдахаар байна” [Ш.Гаадамба 1990: 311] гэхчлэн тайлбарласан байдаг.

Академич Д.Цэрэнсодном гуай “Эл үгийг судлагчид элдэв янзаар таамаглаж зөрүүтэй санал гаргасаар ирсэн нь хажуугийн хөрвүүлгийн орчуулгыг нарийвчлан анхаарч ухаж чадаагүйгээс болсон бололтой. Тухайлбал эл үгийн талаар тусгай өгүүлэл зориулан бичсэн Ш.Гаадамба (1976, 156) “кэкэ” гэдгийг “эх” гэж үзсэн нь илэрхий эндүүрэл болов. Харин проф. Э.Хэниш (1948, 32) хажуугийн хөрвүүлгийн орчуулгыг баримтлан уг үгийн утгыг герман хэлээр зөв буулгасныг тэмдэглэе. МНТ-г орчин

* МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхим

цагийн монгол хэлээр хөрвүүлэгчдээс Мансан ‘гэгэ’ гэгч хүүхэд төрөхөд урьдаар ус гардаг. Орчин цагийн монгол хэлэнд ‘гэгэ’ гэдэг гээх, орхихын утгатай нэр үг “хүүхэд агуулсан ‘ихэс’ мэтийн зүйл болой” гэж тайлбарлажээ. Хүн малын хойтохын шингэнийг (усыг) хуучин Баргын аман аялгуунд “хэхий” гэдэг гэж Бээжин их сургуулийн дэд проф. Чүлтэм багшийн надад ярьсан нь найманы аман ярианд мөн хойтохын усыг “хэху” гэж хэлдэг гэсэн мэдээтэй (Элдэнтэй, Ардаажав, 1986, 320) яг нийцэж байна. Тэрчлэн орчин цагийн монгол хэлний төрөхийн хойтохыг “эхэс” гэж хэлдэг нь уг үгийн эхний “х” авиа гээгдсэн олон тооны хэлбэр бололтой. Дээр өгүүлсэн баримт, жишээнээс үндэслэн бид эл зүйр үгийг:

“Хээл нэгтэн

Хэхий (эхэс) гагцтан” гэсэн үг гэж ухаж байна. (241)

Эрдэмтэн М.Ууганбаяр “МНТ-ны 121-р зүйл дэхь ‘ке’эли никэтэн кэхэ какчатан’ хэмээх хэллэгийг эрдэмтэд янз бүрээр ухчилсан бөгөөд хамгийн маргаантай үг болох ‘хэгэ’-г бид орчин цагийн монгол хэлнээ идэвхтэй хэрэглэгдэх ‘хэгэ’ юмуу үр хөврөлийн гадуур бүрхэх хальс гэсэн үг хэмээн бодоод чинагшид ‘хээл, хэвэл, хэгд, хэгз, хэгж’ зэрэг үгтэй язгуураар холбогдох ‘хэгзрэн унах юм’ гэсэн шиг утгатай үг гэж үзлээ. ‘Хээл’ хэмээх үгийг судлаачид санал нэгтгэйгээр гэдэс хэвэл гэж ойлгодог атал Ш.Гаадамба авгай хээл юмуу үр зулзага гэж ухаарсныг бид шилжсэн утга гэж бодож байна” гэжээ. (М.Ууганбаяр, 1996, 176)

Энэ хэллэгийн анхаарал татаж байгаа *keke* хэмээх нэр томъёо нь анагаах ухааны бие бүтцийн холбогдолтой зүйл гэдэг нь тодорхой болж байгаа бөгөөд бидний үзэхээр бол энэ үгийг өмнөх *ke’eli* хэмээх үгнээс ангид авч үзэж болохгүй юм. Учир нь *ke’eli* гэдэг бол эхийн ургийн нэр бөгөөд *keke* гэдэг түүнийг агуулагч савын утга болж байна. Өөрөөр хэлбэл, *ke’eli*, *keke* хоёр нь агуулагч, агуулагдагчийн харьцаатай гэж хэлж болно.

Энэ хэллэгийг англи хэлээр хэрхэн орчуулсаныг харвал:

Вэй Квэй Сун

My celebrated ancestor, Boduanchar, captured a woman who gave him two sons, the ancestors of Jamukha and myself.

(Миний өвөг дээдэс Бодончар нэгэн эмийг барин олзолж түүнд хоёр хүү төрүүлж өгсөн нь Жамуха, бид хоёрын өвөг дээдэс юм)

Ф.В.Кливез

Jamuγa we were ones of whom The [mother’s] belly [was] one [and the same] [and of whom] The water of the mother’s womb [was] an only [one].

(Жамуха бид хоёр нэгэн эхийн нэгэн хэвлийгээс гарсан, эхийн умайн ус ч адил)

Пол Кан

Because of this, we're such close kin to Jamugha that we're just like people who share the same mother's belly, like people who come from the waters of the same mother's womb.

I [shared] one womb with Jamuqa, but sprang from a different seed.

Игорь де Рахивельз

We are from the same womb, We are from the one womb water as Jamuqa.

Н.Доржготов,З.Эрэндоо

We are from the same womb,
We are from the same amnion as Jamuqa
We would not have parted with him.

(Нэгэн эхийн умайн уснаас гарсан, нэгэн эхийн хэвлийг хуваалцсан хүмүүс шиг бид Жамухын ойрын төрөл садан юм)

Өргөнгөө Онон

(Жамуха бид хоёр нэгэн умайг хуваалцсан боловч өөр өөр үрээс үрсэлсэн)

(Бид нэгэн ижил умайгаас төрсөн, Жамуха шиг бид нэгэн умайн уснаас төрсөн)

(Бид нэгэн умайгаас төрсөн, Жамуха шиг бид ижил усан бүрхүүлээс гарсан)

Бид түүнээс салшгүй)

Оксфорд, Вэбстерийн тайлбар толиудад *womb*- гэдэг нь the organ in women and female animals in which babies develop before they are born, anat.uterus буюу эмэгтэй хүн ба эмэгчин амьтанд байх эрхтэн бөгөөд үр хүүхэд, төл нь гарахаасаа өмнө тэнд өсөж хөгждөг, анатомын нэр томъёогоор *umai; belly*- гэдэг нь the front part of the human trunk below the ribs, containing the stomach and bowels, anat.abdomen буюу хүний цээжин талын хавирганаас доош орших ходоод, гэдэс бүхий хэсэг, анатомын нэр томъёогоор *хэвлий*, мөн амьтны *хэвэл* гэжээ.

С.Шагжийн найруулан зохиосон “Монгол үгний тайлбар толь”-д *хэгэл* гэдэг бол “*гүү зэргийн дотор тогтсон зулзагыг хэлнэ*” гэж тайлжээ. (Шяҗа 1994, 360) Мөн Я.Цэвэлийн толинд “эм адгуусны хэвэл дотор тогтсон үр зулзага” (Я.Цэвэл 1966, 768) хэмээн тайлбарласан байна. Хэдийгээр орчин цагийн монгол хэлэнд *ke'eli* гэдэг үг нь үр зулзага, ураг гэсэн утгатай байгаа боловч МНТ зохиогдож байх үед энэ үг ямар утгатай байсныг мэдэх нь чухал юм. Тэгвэл §38 зүйлд гарах *dumda ke'elitei eme-yi* (911:22b-2, 19) гэсэн үгийг МНТ судлаачид хэрхэн ухаарсаныг мөшгөн үзвэл Ш.Гаадамба “*думда кэгэли тай эмэ*- гэснийг галиглах талаар судлагчид онц зөрөөгүй. Харин утгыг ойлгох талаар гэвэл Кливез хүүхэдтэй эмтэй дайралдаж Бодончар чи хар хүнтэй юу гэсэн утгаар асуусан мэтээр (42, 8) гэснээс бусад нь жирэмсэн байх хугацааны дунд орсон (Хэниш, Пеллио, Рахевильз, Элдэнтэй, Ардажав, Иринчин) гэж зөв ойлгожээ. (Ш.Гаадамба 1990, 237)

МНТ-ны нангиад товч орчуулгад 同胞 *tongbao* – хэвэл нэгтэй буюу “Би мэргэн, хүчирхэг Бодончар богдын барьж авсан эмээс төрсөн Жамухатай хэвэл нэгтэй билээ” хэмээн хураангуйлан орчуулсан байна.

Дээрх зургаан орчуулгын харьцууллаас үзэхэд Вэй Квэй Сун нь МНТ-ны уг эхийн *ke'eli niketen keke qaqcatan* хэмээх хэллэгийг үндсэнд нь орчуулалгүй гээгдүүлэн ерөнхий утгаар нь тоймлон гаргажээ.

Ф.В.Кливез, Пол Кан нар энэ хэллэгийг хэвлий нэгтэн, эхийн ус нэгтэн гэж хадмал хятад орчуулгад тулгуурлан орчуулсан байхад Игорь Рахевильз ижил умайгаас, нэгэн умайн уснаас төрсөн гэж орчуулжээ. Харин Өргөнгөө Онон хээл гэдэг үгийг *seed* (үр) гэж орчуулсан нь эхийнхээ утга санаанд ойр, нэг эхийн хэвлийд хоёр өөр хүн тээгдэн төрсөн гэдэг утгаараа утга зохиолын уран яруу хэрэглүүрийн талаасаа энэ хувилбар оновчтой болжээ. Н.Доржготов, З.Эрэндоо нарын орчуулгын хувьд англи хэлээр ургийн усыг мэргэжлийн нэр томъёогоор *amniotic fluid* гэж нэрлэх боловч утга зохиолын хэл найруулгад мэргэжлийн үг хэллэг (*amnion*) хэрэглэх нь найруулгын хувьд тохиромжтой бус байдаг учраас *water of womb* гэж орчуулсан бол арай дээр байх байсан болов уу.

Дүгнэн хэлбэл МНТ-нд гарч байгаа энэхүү хээл гэдэг үг бол ургийг агуулагч эхийн савыг бус, агуулагдаж буй ургийг нь хэлсэн бөгөөд ургийг агуулагч савыг хэхэ хэмээсэн нь тодорхой байна. Ийнхүү бид энэ хэллэгийг шүлэгчилсэн хэлбэрээр доорх байдлаар англи хэлээр орчуулах саналтай байна.

**Coming from the same womb and
Carried by the same mother**

НОМ ЗҮЙ

- Ш.Гаадамба (1990), *Монголын Нууц Товчоо*, Улаанбаатар.
Монголын Нууц Товчоо (2005), Сонгомол эх, Улаанбаатар.
Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал - 1, (2006), Улаанбаатар.
Д.Пүрэвдорж (2006), *Монгол Улсын Нууц Товчооны шинэ орчуулга тайлбар*, Улаанбаатар.
Д.Цэрэнсодном (1993), *Монголын Нууц Товчооны орчуулга тайлбар*, Үндэстний хэвлэлийн хороо.
М.Ууганбаяр (1996), *Монголын Нууц Товчооны зарим үг хэллэгийн тайлбар*, Улаанбаатар.
Ш.Чоймаа (2011), “*Монголын Нууц Товчоон*”, Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг, Улаанбаатар.
Элдэндэй Ардажав (1986), *Монголын Нууц товчоон-Сийрүүлэл тайлбар*, Өвөр Монголын Сурган Хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөх хот.
Cleaves, F.W (1982), *The Secret History of the Mongols: For the First Time Done into English out of the Original Tongue and Provided with an Exegetical Commentary*. Harvard University Press.
Dorjgotov, N, Erendo, Z (2006), *The Secret History of the Mongols*. Ulaanbaatar.
Igor de Rachewiltz (1972), *Index to the Secret History of the Mongols*, Bloomington.
Igor de Rachewiltz (2004), *The Secret History of the Mongols. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century*. BRILL.
Oxford Advanced Learner's Dictionary of Current English (2000), Oxford University Press.
Paul Kahn (1984), *The Secret History of the Mongols: The Origin of Chinghis Khan*. North Point Press. San Francisco.

Urgunge Onon (2001), *The Secret History of the Mongols. The Life and Times of Chinggis Khan*. London.

Wei Kwei Sun (1957), *The Secret History of the Mongol Dynasty* (Yuan-Chao-Pi-Shi). Muslim University, Aligarh.

www.merriam-webster.com

<http://oxforddictionaries.com>

<http://www.thefreedictionary.com>

SUMMARY

In this article, author deals with the expression “*ke’eli niketen keke qaqqatan*” in the paragraph §121 of the Secret History of Mongols. The Mongolian and English translations are also examined. According to the author, *ke’eli* and *keke* have relationship through their translations of ‘container’ and ‘thing contained’ respectively. Analyzing the above explanations then translates as: Qorči came, saying: “We were born of the woman who captured by Bodončar Boqdo; we were

Coming from the same womb and
Carried by the same mother.